



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

Г

Компанийн 2023 оны бизнес  
төлөвлөгөөг батлах тухай

Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг ханган биелүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Э.Эрдэнэхишиг/-нд даалгасугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 04

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын  
төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.9, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 9.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн тогтоосон хугацаанд хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт, хурлыг тухай бүр журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Нарантуяад тус тус даалгасугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ  
ДОРНОД БҮСИЙН  
НИЙТЭМ ТӨХЖИЙН  
УТРО374 ш 2628651  
ДОРНОД АЙМАГ



## 1. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Компанийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний тухай	1 сар	Гүйцэтгэх захирал
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөө батлах тухай	1 сар	ТУЗ
3	Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө батлах	1 сар	Гүйцэтгэх захирал
4	50 МВт-ын төслийн санхүүжилтын зээлийн гэрээг сунгах тухай	1 сар	Гүйцэтгэх захирал
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ажлын тайлан	2 сар	ТУЗ
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсөв	2 сар	ТУЗ
5	Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдлийн тухай	2 сар	Гүйцэтгэх захирал
6	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг батлах тухай	3 сар	ТУЗ
7	Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн дүнгийн тухай	3 сар	СБХ-ийн дарга
8	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үүрэг, зорилтот түвшингийн биелэлтийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх	3 сар	Гүйцэтгэх захирал
9	Ногдол ашгийн тухай	3 сар	Гүйцэтгэх захирал
10	2022 оны худалдан авах ажиллагаанд хийсэн компанийн дотоод аудитын тайлан, дүгнэлт	3 сар	Дотоод хяналтын албаны дарга
11	2022 оны дотоод хяналтын ажлын тайлан	3 сар	Дотоод хяналтын албаны дарга
12	Компанийн 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан	4 сар	ЭБАТ
13	Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай	4 сар	СБХ-ийн дарга
14	Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий гэрээ байгуулах	5 сар	ТУЗ
15	Компанийн 2022-2023 оны өвлийн их ачааллыг давсан тухай тайлан	5 сар	Ерөнхий инженер

16	Компанийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, техник эдийн засгийн үзүүлэлтийн гүйцэтгэлийн тухай	7 сар	СБХ-ийн дарга
17	Компанийн 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөний биелэлтийн явцын тухай	7 сар	ХҮХ-ийн дарга
18	Компанийн 2022-2023 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний явцын тухай	9 сар	Ерөнхий инженер
19	2023 оны их болон урсгал засварын ажил, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын явцын тухай	10 сар	Ерөнхий инженер
20	Компанийн 2023-2024 оны өвлийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан тухай	10 сар	Ерөнхий инженер
21	Компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний төслийн тухай	11 сар	Гүйцэтгэх захирал
22	50 МВт-ын төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын явц	Шаардлагатай нөхцөлд	ТХН
23	Цаг үеийн шаардлагатай асуудлыг тухайн үед нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж оруулан хэлэлцэн шийдвэрлэх	Тухай бүр	Холбогдох албан тушаалтан

## 2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	ТУЗ-ийн хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах этгээд
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны дүгнэлт гаргах	3 сар	Аудитын хороо
2	Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл олгох саналд дүгнэлт гаргах	3 сар	Цалин урамшууллын хороо
3	Компанийн үйл ажиллагаатай танилцах	3 сар	ТУЗ-ийн гишүүд
4	Компанийн 2023 оны санхүүгийн болон худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх /төв компани дээр /	4,10 сар	Аудитын хороо
5	Гүйцэтгэх захирлын гэрээний үүргийн биелэлт, зорилтот түвшний үзүүлэлтэд хяналт тавьж ажиллах	Тухай бүр	ТУЗ-ийн гишүүд
6	Компанийн тухай хуулийн 81.4-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах	Тухай бүр	Аудитын хороо
7	Компанийн тухай хуулийн 81.5-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах	Тухай бүр	Нэр дэвшүүлэх хороо
8	Компанийн тухай хуулийн 81.6-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах	Тухай бүр	Цалин урамшууллын хороо



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хурлын 03 дугаар тэмдэглэлд:

**“ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ажлын тайлангийн тухай.

**ТЭМДЭГЛЭСЭН НЬ:**

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2022 онд нийт 13 удаа хуралдаж, 27 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 20 тогтоол, 11 тэмдэглэл, ТУЗ-ийн дэргэдэх хороодын 5 дүгнэлт, 18 зөвлөмжөөр компанийн гүйцэтгэх удирдлагад, эрх бүхий албан тушаалтанд үүрэг даалгавар өгсөн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны шийдвэрийн биелэлт 88 хувь, ТУЗ-ийн дэргэдэх хороодын зөвлөмжийн биелэлт 60 хувьтай байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, ТУЗ-ийн дэргэдэх хороодын зөвлөмжийг биелүүлээгүй, зохих хугацаанд ТУЗ-д танилцуулаагүй тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлбар гарган Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөхийг холбогдох ажилтнуудад үүрэг болгов.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, ТУЗ-ийн дэргэдэх хороодын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авч, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав” гэжээ.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР